



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 04 -ны өдөр

Дугаар 1/10

Эрдэнэт

Г Коронавируст халдвар/ Ковид-19/-ыг илрүүлэх Г
шинжилгээг төлбөртэй хийх тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 8.1.8 дахь заалт, Монгол Улсын Шадар Сайд, Эрүүл мэндийн Сайдын хамтарсан 2021 оны 05/А/12 тушаал, Засаг даргын 2021 оны А/53 захирамжийн 3 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Түргэвчилсэн шинжилгээ авах цэгийн бэлэн байдлыг хангаж, иргэдээс шинжилгээ авах ажлыг зохион байгуулахыг Хариу арга хэмжээний баг /А.Баярхүү/-д үүрэг болгосугай.
2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг илрүүлэх шинжилгээний оношлуур, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг тарсалтгүй хангахыг эмийн чанар аюулгүй байдал зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн /О.Анхбаяр/-т даалгасугай.
3. Төлбөрийг 100210020402 төрийн сангийн дансанд төвлөрүүлэн, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Санхүү бүртгэл мэдээлэл нягтлан бодох бүртгэлийн ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

